МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 26 өдөр Дугаар А/367 Мөрөн сум

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний алба болон бусад төрийн үйлчилгээний албан тушаалын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3, 11 дүгээр зүйлийн 11.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20, 14.2.12, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны бүтэц, орон тоог нэгдүгээр хавсралтаар, төрийн үйлчилгээний бусад албан тушаалын орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2. Энэхүү захирамжийг 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс мөрдөн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Захирамжийг албажуулснаас хойш ажлын 3 өдөрт багтаан Төрийн үйлчилгээний албан тушаалтнуудад танилцуулж, шийдвэрийг мэдэгдсэн талаарх баримтыг бүрдүүлж, бүтцийн өөрчлөлтөд орж байгаа албан хаагчдад мэдэгдэл хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Х.Цэнд-Аюуш)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны "Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны бүтэц, орон тоог шинэчлэн батлах, төрийн үйлчилгээний бусад албан тушаалын орон тоог тогтоох тухай" А/194 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

671 2010817

Аймгийн Засаг даргын 2023
оны .06.. дүгээр сарын.26.өдрийн
А/..367 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/д	Төрийн үйлчилгээний бүтэц, орон тоо шинэчлэгдсэн (санал)	Зэрэглэл	Орон тоо
1. НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА			
Нэг. Захиргаа, аж ахуй			
1	Нийтлэг үйлчилгээний албаны дарга	ТҮ-10	1
2	Нягтлан бодогч (тооцооны)	ТҮ-7	1
3	Нярав	ТҮ-4	1
Хоёр. Ажилчид			
1	Сантехникч, слесарь	ТҮ-3	1
2	Мужаан	ТҮ-2	1
3	Жолооч	ТҮ-3	2
4	Үйлчлэгч	ТҮ-1	7
5	Жижүүр	ТҮ-1	8
		Нийт	**23**

_____o0o_____

Аймгийн Засаг даргын 2023
оны 06 дүгээр сарын 26 өдрийн
А/367 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД АЛБАН
ТУШААЛЫН ОРОН ТОО

2.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД АЛБАН ТУШААЛЫН ОРОН ТОО			
Нэг. Засаг даргад өөрт нь үйлчлэх чиг үүрэг бүхий албан тушаалтнууд			
1	Засаг даргын туслах, хурал зохион байгуулагч	ТҮ-6	1
2	Засаг даргын олон нийттэй харилцах ажилтан	ТҮ-7	2
		Нийт	**3**
Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс			
1	Архивч, бичээч	ТҮ-5	1
2	Техникч, тоног төхөөрөмж хариуцсан ажилтан	ТҮ-5	1
3	Угтах үйлчилгээний ажилтан	ТҮ-1	1
		Нийт	**3**
Гурав. Хууль, эрх зүйн хэлтэс			
1	Архивын сан хөмрөгийн эрхлэгч	ТҮ-6	1
2	Лавлагааны архивч	ТҮ-5	1
3	Архивын цахимжуулалт хариуцсан ажилтан	ТҮ-2	1
		Нийт	**3**
Бүгд: 9			

_____o0o_____